

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 07 дугаар сарын 05

Улаанбаатар хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
“НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр тусгасан 209 арга хэмжээнээс нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хамаарах 3 ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тооцон ажиллаж байна.

5.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана. /Хэрэгжилт 100%/

- ✓ Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад шилжүүлэх замаар хэрэгцээ шаардлагыг хангах зохицуулалт хийх, шаардлага хангахгүй хөрөнгийг акталж устгах, шинээр хөрөнгө худалдан авах асуудлыг оновчтой шийдвэрлэж, зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлэх

Төсвийн зардал хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг судлан, НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын дагуу үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын шийдвэрийг үндэслэн 2016-2019 онуудад нийт **142,418,539,041.0** төгрөгийн шинээр хөрөнгө худалдан авах, бүртгэх, балансаас балансад шилжүүлэх, данснаас хасах зэрэг хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:

- ✓ 2016 онд - 88,813,578,201 төгрөг
- ✓ 2017 онд - 20,664,994,549 төгрөг
- ✓ 2018 онд - 28,366,055,606 төгрөг
- ✓ 2019 онд - **4,573,910,685 төгрөг /5,566,683,742**

2017 оны худалдан авалт 2016 оныхоос 51,316,068 төгрөгөөр, 2018 оны худалдан авалт 2017 оныхоос 958,470,352 төгрөгөөр буурч, 2019 оны эхний хагас жилийн худалдан авалт 2018 оны мөн үеэс 18,176,039 төгрөгөөр өссөн байна.

- ✓ Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, төрөл, нормативыг тогтоох, хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах /Хэрэгжилт 100%/

Нийслэлийн өмчит байгууллагуудын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн нарийвчилсан судалгааг гаргаж автомашины тоо, төрөл, үнэлгээ, автомашинтай холбоотой гарсан зардлыг тооцох ажлыг зохион байгуулсан бөгөөд ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолыг

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

хэрэгжүүлэх ажлын хүрээнд өдөрт 60 км явах лимитийг бууруулан 40 км болгосноор шатахууны зардлыг нийт **1,399,605.0** мянган төгрөгөөр бууруулах нөхцлийг бүрдүүлсэн.

Нийслэлийн өмчит байгууллагуудын тээврийн хэрэгслийн нарийвчилсан судалгааг гаргаж автомашины тоо, төрөл, үнэлгээ, автомашинтай холбоотой гарсан зардлыг тооцсон.

Нийслэлийн өмчит 454 байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан балансаар 163,296,102,278.4 төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгсэл бүртгэлтэй бөгөөд үүнээс тээврийн хэрэгслийн хуримтлагдсан элэгдэл 111,512,394,413.4 төгрөг, автомашинтай холбоотой зардал 51,913,414,174.0 төгрөг байна.

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн мэдээллийн системийг боловсронгуй болгох /Хэрэгжилт 100%/

“Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТӨБЗГ-аас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-тай хамтран боловсруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн программыг 4 дэх жилдээ ашиглаж, мэдээллийг жил бүр шинэчлэн, сайжруулах ажлыг хийж байна.

Нийслэлийн өмчит 770 байгууллагын тайлан балансыг хүлээн авч нэгтгэн 2018 оны жилийн эцсийн балансаар нийт хөрөнгө 3,823,212.8 сая төгрөг үүнээс эргэлтийн бус хөрөнгө 3.219.405,8 сая, эргэлтийн хөрөнгө 603807,1 сая төгрөг байна. /Элэгдэл тооцоогүй дүнгээр буюу бүртгэлийн анхны үнээр авч үзвэл нийслэлийн өмчийн эргэлтийн бус хөрөнгө 3.839.172,7 сая төгрөгт хүрчээ./ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Үндэсний Статистикийн газарт 770 байгууллагын өмчийн бүртгэлийн дүн мэдээг ТӨ болон ТӨХ маягтуудын дагуу тайлагнаж хүргүүлэв.

- 2016 онд - 1,339,937,300,000.0 төгрөгийн хөрөнгө
- 2017 онд - 1,796,109,149,722.0 төгрөгийн хөрөнгө
- 2018 онд - 2,087,887,100,000.0 төгрөгийн хөрөнгө
- 2019 онд - 3,816,592,491,876.7 төгрөгийн хөрөнгийн мэдээллийг шинэчлэн системд оруулсан.

1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:
/Хэрэгжилт 63,3%- тодорхой үр дүнд хүрсэн/

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 1 зорилтын хүрээнд Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нь үндсэн чиг үүргийнхээ дагуу Эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 2 ажлыг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

1.6.1 Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ.

Нийслэлийн өмчид байгаа хөрөнгө, өмчит үйлдвэрийн газруудын үр ашгийг нэмэгдүүлж, шинэ механизмыг нэвтрүүлнэ. /Хэрэгжилт 10%/

Компаний засаглалын Үндэсний зөвлөлтэй хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулан, нийслэлийн өмчит хувьцаат компани, үйлдвэрийн газруудад компаний засаглалыг хэрэгжүүлэх дүн шинжилгээ хийлгэхээр төлөвлөсөн. Одоогийн байдлаар байгууллагын бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор түр хугацаагаар хойшлогдоод байна.

1.6.6 Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх, үл хөдлөх хөрөнгийг үнэлэх ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авна. /Хэрэгжилт 100%/

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх аргачлал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 367 дугаар тогтоолоор батлагдсан зааврын дагуу нийт 9 дүүргийн нийслэлийн 100 хувийн өмчтэй 520 төсөвт байгууллага хамрагдан, үнэлгээг батлагдсан маягтын дагуу тулгалт хийн шалган авлаа.

Нийслэлийн өмч газар эзэмших эрхийн үнэлгээгээр 4 203,89 га талбайтай 1255 нэгж талбар **893,743,200,000.0** төгрөг, барилга байгууламж дахин үнэлгээний нэмэгдлээр **1,372,317,091,922.1** төгрөгөөр үнэлэгдэн, барилга **615,638,163,057.5** төгрөгөөр нэмэгдэж, нийслэлийн өмч нийтдээ **1,502,761,027,939.2** төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Мөн нийслэлийн өмчийн барилга байгууламжийн 2018 оны бүртгэл, үнэлгээний нэгтгэлд 520 хуулийн этгээдийн 23970 нэрийн 1,292,267.4 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий хөрөнгийг нэгтгэж 1 372,317.1 сая төгрөгөөр үнэлэгдсэн байна.

Дахин үнэлгээгээр 2018.12.31-ний өдрийн байдлаар байгууллагын балансад бүртгэлтэй 176 хөрөнгийн дутагдсан 11,290,346.5 мянган төгрөгийн, 76 хөрөнгийн маргаантай 3,330,323.7 мянган төгрөгийн үнэ бүхий устаж үгүй болсон, үлдэх өртөггүй, давхар бүртгэлтэй, буулган барилга баригдсан зэрэг зөрчилтэй байна.

Дүүрэг тус бүрээр задалж харуулвал:

№	Дүүргийн нэр	Дахин үнэлгээнд хамрагдсан						Дүн
		Цэцэрлэг	Сургууль	ӨЭМТ	Эрүүл мэндийн байгууллага	Төр захиргааны болон бусад төсөвт байгууллага	Үйлдвэрийн газар, компани	
1	Багануур	9	3		2	8	5	27
2	Багахангай	2	1		1	6	3	13
3	Баянгол	32	17	2	3	8	6	68
4	Баянзүрх	38	23	3	5	10	11	90
5	Налайх	7	5		1	8	6	27
6	Сонгинохайрхан	40	18	9	4	8	7	86
7	Сүхбаатар	31	17	4	4	9	7	72
8	Хан-Уул	24	17	5	3	8	7	64
9	Чингэлтэй	26	15	3	1	20	8	73
	Дүн	209	116	26	24	85	60	520

Газар эзэмших эрхийн үнэлгээний талаар

Нийслэлийн өмчит 478 хуулийн этгээдийн эзэмшилд буй 1255 нэгж талбарын 42 038 918,69 м² буюу 4 203,89 га газар 887 122,9 сая төгрөгөөр үнэлэгдэв.

№	Салбар	Нэгж талбарын тоо	Газрын хэмжээ /м ² /	Газар эзэмших эрхийн үнэ /төг/
1	Цэцэрлэгийн газар	215	934,192.1	19,918,380,640.0
2	Сургуулийн газар	142	1,577,447.7	30,275,275,431.0
3	ӨЭМТ-ийн газар	9	4,673.0	56,253,240.0
4	Эрүүл мэндийн байгууллагын газар	52	342,463.6	7,045,735,724.8
5	Төр захиргааны байгууллагуудын газар	283	3,678,779.2	27,978,917,437.9
6	ЗДТГ-ын газар	300	7,644,719.6	53,917,170,768.0
7	Үйлдвэрийн газрын газар	254	27,856,643.5	747,931,131,640.0
	Дүн	1255	42,038,918.69	887,122,864,881.70

Барилга байгууламжийн үнэлгээний талаар

Нийслэлийн өмчийн барилга байгууламжийн 2018 оны бүртгэл, үнэлгээний нэгтгэлд 515 хуулийн этгээдийн 23 970 нэрийн 1,292,267.4 сая төгрөгийн /1,292,267,397,497.9 төгрөг/ үлдэх өртөгтэй хөрөнгө нэгтгэгджээ. Нийслэлийн өмчит 438 хуулийн этгээд эзэмшилдээ буй 2652 барилгаа үнэлсэн байна.

4.1.9 "Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний загвар" төсөл хэрэгжүүлж, "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрүүл, баталгаат хоол хүнс хэрэглэх нөхцөл бүрдүүлнэ.

Холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина. /Хэрэгжилт 90%/

БЗД-ийн Амгалан цогцолбор сургууль, 142-р сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн сонгон шалгаруулалт болон Өргөө амаржих газар, БГД-ийн ЭМН-ийн хүүхдийн эмнэлгийн цайны газрын түрээслэгч сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж, хяналт тавин ажилласан.

Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу сургуулийн удирдлагууд, аж ахуй нэгжийн төлөөллийг оролцуулан нийслэлийн Ерөнхий Боловсролын 102 дугаар сургууль "Арвин мөнх дэлгэрэх" ХХК, 132 дугаар сургууль "Элсэн сондор" ХХК-д түрээсийн өр авлагыг барагдуулах, СХД-ийн 12 дугаар сургууль Хамада ХХК-тай холбоотой эцэг, эхчүүдийн гаргасан гомдлын мөрөөр арга хэмжээ авах, тохижилтын ажил хийх хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан. Тус сургуулиудын хяналтын комиссын дүгнэлтээр түрээсийн гэрээ дуусгавар болгох хүсэлтийг нэгтгэж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ “ ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлд нийслэлийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 73 ажлыг тусган, үе шаттай зохион байгуулан хэрэгжилтийг ханган биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

1. Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

2. Байгууллагын үйл ажиллагаанд байнга мөрдөж ажиллах заавар, журам, стандартыг хэрэгжүүлэх, 2019 оны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр шалган зааварлах ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө

3. "Иргэдийн оролцоотой - Хөгжлийн жил"-ийн хүрээнд 2019 онд хийх ажлын төлөвлөгөө

4. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2019 оны төлөвлөгөө


5. "Мэдээллийн цаг" сургалтын төлөвлөгөө

6. Шинээр санаачлан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

7. Архивын ажлын төлөвлөгөө

8. Засгийн газрын 2017 оны 01 албан даалгавар, Засгийн газрын 2018 оны 32, 258 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

2.1. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт



Тогтоол, шийдвэр, захирамжийн биелэлтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар гарган, гүйцэтгэлийг тооцсон. Үүнд:

		Нийт	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэмдэглэл	НЗД-ын захирамж
Хяналтад авсан нийт шийдвэрлэлтийн тоо		23	4	3	13	3	38
Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо		49	13	20	13	3	
Бүрэн хэрэгжсэн	100%	14	16	7	1	-	33
Хэрэгжих шатандаа	70%	-	2	5	1	-	5
Хэрэгжилт хангалтгүй	30%	1	-	-	1	-	
Хэрэгжээгүй	-	-	-	-	-	-	
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй /үнэлэх боломжгүй/		1	-	1	-	-	
Биелэлтийн дундаж		92%	95%	96%	70%	66%	98%

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гарсан захирамж - 38

100% - бүрэн хэрэгжсэн	33
90% - хэрэгжих шатанд	3 – А/168, 455, 506
70% - хэрэгжих шатанд	1 – А/42
50% - хэрэгжих шатанд	1 – А/185

Хөрөнгө оруулалт, эрх шилжсэн ажлуудын захирамж - 108

1. Захиалагчийн хяналт тавих	24
✓ Хэрэгжих шатанд	- 6 – 70%
✓ Хугацаа болоогүй	- 18 – 0%
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах	- 1 - 70%
3. Хөрөнгө бүртгэх	- 83 – хугацаа болоогүй

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн болон байгууллагын шуурхай зөвлөгөөний талаар

	Хурлын тоо	Үүрэг даагавар	Биелэлт
Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн	11 удаа	44	100%
Байгууллагын шуурхай зөвлөгөөн	16 удаа	123	94,4%

Байгууллагын 7 хоногийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, албан хаагчдын 7 хоногийн үр дүнгийн үнэлгээг нэгтгэн, НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хугацаанд нь тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсний эхний 100 хоногт хийж хэрэгжүүлсэн томоохон 5 ажлын тайланг гарган НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2019.06.05-ны өдрийн 1/676 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлыг 3 удаа, Ёс зүйн хороог 1 удаа хуралдуулан, хурлын тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулан, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Тайлант хугацаанд газрын даргын шуурхай хурал 16 удаа зохион байгуулагдаж давхардсан тоогоор нийт 123 үүрэг даалгавар өгөгдөж, үүрэг даалгаврын хэрэгжилт 94,4%-ийн биелэлттэй байна.

- ЗСХ -41 үүрэг даалгавар
- ӨТМХ -38 үүрэг даалгавар
- ӨМХАХ -24 үүрэг даалгавар
- ӨБХХ -21 үүрэг даалгавар

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

ГУРАВДУГААР БҮЛЭГ “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН” ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:

Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын удирдлагын болон үргүй зардлыг үе шаттай бууруулна.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/185 дугаар захирамжаар “Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан 2018 оны контрактыг дүгнэх, 2019 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төсөл бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг байгуулан, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 16 үйлдвэрийн газрын 2018 оны зорилтот түвшний биелэлт, 2019 оны орлого, зардал, ашиг алдагдал, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг хэлэлцүүлэх ажлын бэлтгэл хангагдаад байна.

Өнгөрсөн 2018 онд үйл ажиллагаа явуулсан орон нутгийн өмчит 16 үйлдвэрийн газрууд нийт 244,3 тэрбум төгрөгийн орлого олж, 275,4 тэрбум төгрөгийн зардал гарган 31,0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнээс орлогын төлөвлөгөө 109,1 хувийн биелэлттэй, зардал 8,5 хувиар давж, алдагдлын хэмжээ зорилтот түвшингээс 1,2 тэрбум төгрөгөөр буюу 4,2 хувиар өссөн байна.

Үйлдвэрийн газруудаас ирүүлсэн 2019 оны эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх зорилтын төслийг хянан орлогыг 263,0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, зардлыг 308,9 тэрбум төгрөг, алдагдлыг 45,9 тэрбум төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1,17 төгрөгөөр батлуулахаар танилцуулга, контрактын төслийн санал боловсруулаад байна.

№	Үзүүлэлт	2018 он	2018 он	2018 он	2018 он	2019 он	2018 оны гүйцэт гэлээс
		зорилт	гүйцэтгэл	зөрүү	Биелэлт хувиар	Зорилт	
1	Нийт орлого	223,988,172.7	244,395,459.6	20,407,286.8	109.1	263,038,888.6	18,643,429.0
2	Нийт зардал	253,813,124.8	275,491,572.2	21,678,447.4	108.5	308,948,636.2	33,457,064.0
3	Нийт ашиг/алдагдал	-29,824,952.0	-31,096,112.6	-1,271,160.5	104.2	-45,909,747.6	14,813,635.0
	Борлуулалтын 1 төг. ногдох зардал	1.13	1.13	1.06	1.00	1.17	0.05

Мөн дээрх 15 үйлдвэрийн газраас ирүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дээд хязгаарыг 23,3 тэрбум төгрөг байхаар хянаж өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр шинээр хийгдэх хөрөнгө оруулалт, шинэчлэлтийн ажил худалдан авах хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь багцлан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолыг баримтлан хөрөнгө худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахыг зөвлөн ажиллаж байна.

3.1.2. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бүтэц, зохион байгуулалт, дүрэмд өөрчлөлт оруулах талаар :

Нийслэлийн төсвийн ачааллыг бууруулах зорилгоор “Минж нутагшуулах төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг татан буулгаж, Нийслэлийн Байгаль орчны газарт нэгтгэх асуудлыг судлан танилцуулга, тогтоолын төсөл боловсруулж, НИТХТ-ийн хуралд өргөн барьж хэлэлцүүлэн

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2019.01.23-ны өдрийн 17 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Тогтоолын дагуу НЗД-ын 2019.02.26-ны өдрийн А/168 дугаар захирамжаар “Минж нутагшуулах төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг татан буулгах, нэгтгэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилсон.

Үүнд:

- Журмын дагуу тус байгууллага татан буугдаж байгаа тул өр авлагатай иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд тооцоо нийлэх талаарх зар мэдээг Өдрийн сонины 2019.03.06-ны өдрийн дугаарт байршуулсан.
- Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст тус газарт татварын хяналт оруулж, дүгнэлт гаргаж өгөх талаар 2019.03.06-ны өдрийн 2/267 тоот албан бичгийг хүргүүлэв.
- Ажлын хэсэг 2019.04.03-ны өдөр тус байгууллагын хөрөнгийн тоо хэмжээ, үнэ өртгөөр нь тулган хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан.

НИТХТ-ийн 2019.02.01-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн харьяа нэгж болгон зохион байгуулах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 179 дүгээр тогтоолоор “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулж, компаний дүрмийг баталлаа.

“Нийслэлийн 2019 оны төсөвт зохицуулалт, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 23/15 дугаар тогтоолоор “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент” ХХК-ийн дүрмийн санд нийлүүлэх 5,0 /таван/ тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд зориулсан 300,0 /гурван зуун/ сая төгрөгийг шилжүүлэх тухай НЗД-ын 2019 оны А/605 дугаар захирамж гаргуулан, Гүйцэтгэх захиралтай нийслэлийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих гэрээг байгуулав.

НИТХТ-ийн 2019 оны 65 дугаар тогтоолоор “Улаанбаатар спорт менежмент” хувьцаат компанийг байгуулж, компаний дүрмийг баталсан. Нийслэлийн 2019 оны төсвийн 3.2.73-д тусгасан “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болох 5,0 тэрбум төгрөгийг шилжүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/493 дугаар захирамж гаргуулан, Гүйцэтгэх захиралтай нийслэлийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих гэрээг байгуулсан.

3.1.3. НӨҮГ болон оролцоотой компанийн ТУЗ, УЗ-д нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх:

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн 8 газрын 1 удаагийн хуралд холбогдох мэргэжилтнүүд оролцож нийслэлийн өмчийн бодлого, менежментийн талаар саналаа тусгуулж ажиллаа. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар
- Улаанбаатар зам засвар арчлалтын газар
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар
- Зорчигч тээвэр Гурав
- Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
- Хот тохижилтын газар
- Зураг төслийн хүрээлэн
- Геодези усны барилга байгууламж

3.1.4. Төсөвт газруудтай байгуулсан Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэх ажлын талаар:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 55 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ын дагуу Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

ний 2018 оны биелэлтийг дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг томилогдон, Нийслэлийн өмчит нийт 599 байгууллагын өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэлээ.

№	Дүүрэг	Дүгнэсэн байгууллагын тоо
1	Баянзүрх	110
2	Баянгол	70
3	Баганхангай	16
4	Сүхбаатар	90
5	Сонгинохайрхан	100
6	Хан-Уул	88
7	Чингэлтэй	95
8	Налай дүүрэг	30

Тус Ажлын хэсэг нь одоогийн байдлаар “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний дүнг нэгтгэн, тайлан, илтгэх хуудсыг боловсруулж байна.

3.2. Хөрөнгийн хөдөлгөөний талаар хийж хэрэгжүүлсэн ажил:

3.2.1. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн ажлын талаар

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламж, гадаад дотоодын хандив бэлэглэлээр нийслэлийн өмчид шинээр бий болсон эд хөрөнгийг эзэмшигч байгууллагын данс бүртгэлд тусгах, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн дансны залруулга хийх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд нийслэл хотод улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын болон дотоодын хандив, буцалтгүй тусламж, зээлийн хөрөнгөөр шинээр бий болсон **нийт 42,139.8 сая төгрөгийн** хөрөнгийг нийслэлийн өмчийн бүртгэлд тусгасан.

Үүнд:

- | | |
|--|----------------------------|
| 1. Барилга байгууламж 27 | 27,039.2 сая төгрөг |
| 2. Тээврийн хэрэгсэл 39 | 2,145.0 сая төгрөг |
| 3. ЭБХХХК-ын хурлаар бүртгэсэн эд хөрөнгө: – | 739,1 сая төгрөг |
| 4. Шинээр бий болсон эд хөрөнгө: – | 12,216.5 сая төгрөг |

Нэг. Барилга байгууламж - 27 нэрийн 27,039.2 сая төгрөг

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, НЗД-ын захирамжаар дараах барилга байгууламжуудыг нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- ✓ БЗД, СБД, СХД-үүдийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон 355,5 сая төгрөгийн өртөг бүхий 8 ус түгээх байр,
- ✓ Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 87,3 сая төгрөгийн өртөг бүхий ус түгээх 2 байрыг
- ✓ БГД-ийн 11 дүгээр хороонд баригдаж ашиглалтад орсон 296,2 сая төгрөгийн үнэ бүхий Ус Дулаан дамжуулах Төвийн барилга байгууламж, тоног төхөөрөмж,

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- ✓ СХД-ийн 21 дүгээр хороололд баригдаж ашиглалтад орсон 3,497,4 сая төгрөгийн өртөг бүхий “Түрээсийн 70 айлын орон сууц”-ны барилга,
- ✓ СХД-ийн нутаг дэвсгэрт баригдаж ашиглалтад орсон нийт 6,935.5 сая төгрөгийн 5 барилга байгууламж,
- ✓ Төрийн өмчөөс нийслэлийн өмчид шилжүүлж байгаа 5,016,9 сая төгрөгийн үнэ бүхий Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн 2655 метр дугуйн зам, цанын зам, гүйлтийн зам, дугуйн зогсоол, Спорт цогцолбор,
- ✓ СБД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдсан 7,999.4 сая төгрөгийн өртөг бүхий 154 айлын түр оршин суух орон сууцны барилга
- ✓ ХУД-ийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан 1,341.3 сая төгрөгийн өртөг бүхий 40 айлын орон сууцны барилга
- ✓ Иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан 551,3 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцны инженерийн шугам сүлжээг
- ✓ ХУД-ийн 13 дугаар хороо, Туул тосгоны нутаг дэвсгэрт баригдсан 344,6 сая төгрөгийн өртөг бүхий 50м3 хүчин чадалтай бага оврын цэвэрлэх байгууламжийг
- ✓ БНД-ийн ОНХСХ-өөр баригдсан 69,8 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг усан санг
- ✓ НТХО-аар баригдсан нийт 9,8 сая төгрөгийн өртөг бүхий 3 автомашины гаражийг Налайх дүүргийн материал, үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд буюу нийслэлийн өмчид бүртгэсэн.

Хоёр. Тээврийн хэрэгсэл 39 – 2,145.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/33, А/41, А/46, А/186, А/328, А/401, А/402, А/456, А/484, А/485, дугаар захирамжуудаар нийт 2,145.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 39 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэх шийдвэрийг гаргуулан, хариуцагч байгууллагуудыг данс бүртгэлдээ тусган, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг мэдэгдэн албан бичиг хүргүүлэн захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Гурав. ЭБХХХК-ын хурлын шийдвэрээр бүртгэсэн эд хөрөнгө – 739,1 сая төгрөг

Төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр ирсэн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөндөө бүртгэх зөвшөөрөл хүссэн байгууллагуудын хүсэлтийг комиссын хурлаар хэлэлцүүлж, давхардсан тоогоор **37** байгууллагын **739,135,458** төгрөгийн эд хөрөнгийг бүртгэх Газрын даргын тушаал гаргасан.

Дөрөв. Шинээр бий болсон эд хөрөнгийг данс бүртгэлд авах тухай албан бичиг хүргүүлсэн байдал – 12,216.5 сая төгрөг

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Автозамын хөгжлийн газар зэрэг захиалагч байгууллага болон төсөл хэрэгжсэн байгууллагуудаас ирүүлсэн улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгөөр бий болсон шугам сүлжээ, автозам, тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлтийн дагуу нийт **12,216.5 сая** төгрөгийн эд хөрөнгийг данс бүртгэлдээ тусгахыг үүрэг болгосон албан бичгийг өмч эзэмшигч байгууллагуудад хүргүүлсэн.

Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, 2019 онд санхүүжих 843 төсөл арга хэмжээний судалгааг жагсаалтаар гаргалаа. Үүнд:

- НТХО-аар хийгдэх – 63,102.6 сая төгрөгийн 364 ажил
- Замын сангийн – 22,021.9 сая төгрөгийн 71 ажил
- НОНХС-ийн – 22,314.8 сая төгрөгийн 264 ажил
- УТХО-аар – 147,322.6 сая төгрөгийн 144 ажил

3.2.2. Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн талаар

Нийслэлийн Засаг даргын захирамжаар дүүргүүдийн өрхийн эрүүл мэндийн төвийн **1,099,895,973** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 10 барилга, тусгай зориулалтын хог тээврийн 22 ширхэг машин, халаалтын зуух, тоног төхөөрөмж зэрэг **5,077,642,109.08** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох газрын балансад шилжүүлсэн.

ЭБХХХК-ын шийдвэрээр 19 байгууллагын **551,107,339** сая төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн байна.

3.2.3. Данснаас хассан хөрөнгийн талаар:

Тайлант хугацаанд НИТХТ-ийн тогтоолоор **959,400,000** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 6 барилга, Нийслэлийн Засаг даргын захирамжаар **51,600,000** төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 53 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлүүлэн, газрын даргын 84 тушаалаар **3,079,732,491.5** /гурван тэрбум далан есөн сая долоон зуун гучин хоёр мянга дөрвөн зуун ерэн нэгэн төгрөг 50 мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий актлагдсан хөрөнгийг татан төвлөрүүлж, 4 удаагийн үнэлгээний комиссын хурлаар үнэлж хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулах ажлыг зохион байгуулан **68,635,300** /жаран найман сая зургаан зуун гучин таван мянган гурван зуун/ төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.


3.2.4. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын хурлыг зохион байгуулах:

ЭБХХХК-ийн 11 удаагийн хурлаар давхардсан тоогоор нийт 172 байгууллагын 3678 нэр төрлийн **5,566,683,742** төгрөгийн үнийн дүн бүхий эд хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн.

Үүнд:

- Шинээр худалдаж авах хөрөнгө: 22 байгууллагын **425,027,817** төгрөг
- Бүртгэх хөрөнгө: 37 байгууллагын **739,135,458** төгрөг
- Балансаас балансад шилжүүлэх хөрөнгө: 19 байгууллагын **551,107,339** төгрөг
- Данснаас хасах хөрөнгө: 98 байгууллагын **3,820,355,315** төгрөг
- Данснаас дансанд хөрөнгө шилжүүлэх: 1 байгууллагын **31,057,813** төгрөг





3.2.5. Нийслэлийн өмчийн мэдээллийн сангийн баяжилтын талаар:

“Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТӨБЗГ-аас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-тай хамтран боловсруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн программыг 4 дэх жилдээ ашиглаж, мэдээллийг жил бүр шинэчлэн, сайжруулах ажлыг хийж байна.

Нийслэлийн өмчит 770 байгууллагын тайлан балансыг хүлээн авч нэгтгэн 2018 оны жилийн эцсийн балансаар нийт хөрөнгө 3,823,212.8 сая төгрөг үүнээс эргэлтийн бус хөрөнгө 3.219.405,8 сая, эргэлтийн хөрөнгө 603807,1 сая төгрөг байна. /Элэгдэл тооцоогүй дүнгээр буюу бүртгэлийн анхны үнээр авч үзвэл нийслэлийн өмчийн эргэлтийн бус хөрөнгө 3.839.172,7 сая төгрөгт хүрчээ./ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Үндэсний Статистикийн газарт 770 байгууллагын өмчийн бүртгэлийн дүн мэдээг ТӨ болон ТӨХ маягтуудын дагуу тайлагнаж хүргүүлэв.

- 2018 онд
 - ✓ Эргэлтийн бус хөрөнгө 3,823,212.8 сая төгрөг
 - ✓ Эргэлтийн хөрөнгө 603,807,1 сая төгрөг
 - ✓ Нийт 3,816,592,491,876.7 төгрөг

3.2.6. Өмч хувьчлалын ажлын талаар:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21 дүгээр тогтоолоор 2019 онд хувьчлагдах 2 аж ахуйн нэгж, 13 барилга байгууламжийн жагсаалт, нийслэлийн төсөвт 90,1 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөг батлуулсан.

Хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн хувьчлалын ажлыг хариуцан ажиллах Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг НЗД-ын 2019 оны А/126 дугаар захирамжаар томилсон.

“Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ, “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын Ахуйн үйлчилгээний төв, Багахангай Мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ зэрэг байгууллагуудыг менежментийн гэрээгээр ажиллуулах этгээдийг сонгон шалгаруулах журам, гэрээний төслийг боловсруулж НИТХТ-ийн 2019.03.22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн 45-48 дугаар тогтоолуудаар батлуулсан. Мөн НИТХТ-ийн 2019.06.10-ны өдрийн 95 дугаар тогтоолоор нийслэлийн өмч хувьчлах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлууллаа.

3.2.7.Барилга байгууламжийн дуудлага худалдааны талаар:

Нийслэлийн өмчөөс 2019 онд хувьчлагдах хуулийн этгээд, эд хөрөнгийн үнэлгээг хийлгэн НӨХК-ын хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, танилцуулгыг боловсруулан хурлын бэлтгэл ажлыг хангаад байна. Үүнд:

1. Булган аймгийн Хялгант тосгонд байрлах “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-ын бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг “Файн эстимэйт” ХХК-тай 2019/01 тоот гэрээ байгуулан 881,5 сая төгрөгөөр
2. “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын Ахуйн үйлчилгээний төвийн бизнесийн, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилгын хөрөнгийн болон газар эзэмших эрхийн үнэлгээг “Ю Би Пропертиз” ХХК-тай 2019/02 тоот гэрээ байгуулан 70,2 сая төгрөг, 55,1 сая төгрөгөөр
3. “Монгол шуудан” ХХК-ийн түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсэг, Багануур дүүргийн 2 дугаар хорооны хуучин барилгын үнэлгээг “Бэсгэ” ХХК-тай 2019/03 тоот гэрээ байгуулан 250,6 сая төгрөг, 34,1 сая төгрөгөөр
4. Баянзүрх дүүргийн Цагдаагийн 3 дугаар хэлтсийн Шар хадны хэсгийн хуучин барилга, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны халуун усны барилга, газар эзэмших эрхийн үнэлгээг “Лэндс” ХХК-тай 2019/04 тоот гэрээ байгуулан 97,5 сая төгрөг, 45,2 сая төгрөгөөр үнэлэн, үнэлгээний тайлангаа ирүүлсэн.

Дараах барилга байгууламжуудын хувьчлалын бэлтгэл ажлыг ханган НӨХК-ын хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө, танилцуулгыг боловсруулан хурлын бэлтгэл ажлыг хангаад байна Үүнд:

1. Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлан авах этгээдийг сонгон шалгаруулах үралдаант шалгаруулалтын хуваарийг батлуулах

- ✓ “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ
- ✓ “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-ын ажиллуулж буй 8 хүний халуун ус бүхий үйлчилгээний төв

2. Шинээр хувьчлах

- БЗД-ийн Цагдаагийн 3 дугаар хэлтсийн Шар хадны хэсгийн хуучин барилгыг 102,260,000 төгрөгөөр
- СБД-ийн 16 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн хуучин барилгыг 55,000,000 төгрөгөөр
- БНД-ийн 2 дугаар хорооны хуучин барилгыг 34,113,000 төгрөгөөр
- “Монгол шуудан” ХК-ийн түрээсээр эзэмшиж байсан байрны 2 дугаар хэсгийг 250,610,000 төгрөгөөр
- СХД-ийн 20 дугаар хорооны Халуун усны барилгыг 100,672,000 төгрөгөөр
- ХУД-ийн 12 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн хуучин барилгыг 62,172,000 төгрөгөөр
- СБД-ийн 10 дугаар хорооны Халуун усны барилгыг 100,621,450 төгрөгөөр

3. Дахин дуудлагын худалдаагаар

- БГД-ийн 10 дугаар хорооны хуучин барилгыг 24,463,600 төгрөгөөр
- БЗД-ийн 9 дүгээр хорооны хуучин барилгыг 76,564,600 төгрөгөөр

4. Өмчлөгчийн эрх олгох

- ХУД-ийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн түр саатуулах байрлаж байсан барилгын өмчлөх эрхийг хувьчилж авсан иргэнд шилжүүлэх

5. Хувьчлалын тайлан батлах

- “Усан спорт сургалтын төв” НӨҮГ-ыг хувьчилсан тухай

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-т заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай 2019 оны өмч хувьчлалын жагсаалтыг зөвшилцөхөөр хүргүүлээд байна.

3.2.8.Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны талаар:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/172 дугаар захирамжаар нийслэлийн өмчит зарим байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдсон тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах асуудлыг баталсан. Тус захирамжийн дагуу 17 байгууллагын 20 тээврийн хэрэгслийг дуудлагаар худалдаж давхардсан тоогоор 20 иргэнтэй худалдах худалдан авах гэрээг байгуулж, нийслэлийн төсөвт 54,1 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

3.3.Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн талаар:

Байгууллагын 2019 оны санхүүжилт болох орон нутгийн төсвөөс **1,114,980.2 сая** төгрөг, жилийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх **449,869.0 сая** төгрөг, нийт **1,564,849.20 сая** төгрөгийн төлөвлөгөө батлагдсанаас зардлын сар, улирлын хуваарийг Нийслэлийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээр батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өнгөрсөн 2018 оны жилийн эцэст үүссэн 28 байгууллагын 88,7 сая төгрөгийн өр авлагаас 24 байгууллагын 54,9 сая төгрөгийн өр авлагыг барагдуулж, нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.

Мөн Аудитын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу балансад тусгагдаагүй байсан 2 байгууллагын 10,5 сая төгрөгийн өр авлагыг балансад тусгасан.

Байгууллагын зардлыг төлөвлөсөн төсвөөс хэтрүүлэхгүй хэмнэж ажилласны үндсэн дээр цалин хөлс, нийгмийн даатгал, бараа үйлчилгээний бусад зардал, хангамжийн материал болон бусад зардлаас 49,935,962.8 /дөчин есөн сая есөн зуун гучин таван мянга есөн зуун жаран хоёр төгрөг наян мөнгөн/ төгрөгийг хэмнэсэн байна.

Эдийн засгийн үзүүлэлт	Төлөвлөгөө / 2019.06 сарын байдлаар /	Гүйцэтгэл / 2019.06 сарын байдлаар /	Хэмнэлт / 2019.06 сарын байдлаар /
Төсвөөс урсгал санхүүжилт	599,034,800.00	599,034,800.00	0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	254,956,400.00	254,956,400.00	0
Үндсэн ба нэмэгдэл цалин	402,319,200.00	361,744,925.00	40,574,275.00
Ажилчдын тоо	65	65	65
Нэг хүнд ногдох дундаж цалин	1,031,587.60	927,551.00	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	37,748,400.00	9,788,680.00	27,959,720.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	15,000,000.00	11,967,698.70	3,145,231.4
Хангамж бараа материалын зардал	23,850,000.0	21,938,581.60	1,911,418.4
Бараа үйлчилгээний зардал	8,670,200.0	4,365,162.00	4,305,038.00

мян.төг/

- Байгууллагын 2018 оны хагас жилийн эцсийн тайлан балансыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хуулийн хугацаанд нь гаргаж “Нийслэл дэх

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- Төрийн Аудит"-ын газраар хянан баталгаажуулж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.
- Байгууллагын 2018 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ/ төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй гэсэн “Аудитын гэрчилгээ” дүгнэлт авсан.
 - Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Баянхошуу дэд төвд баригдаж буй Бизнес инкубатор төв, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах Ашиглалтын захиргаа байгуулах, төсвийн төслийг 229,984,556.60 /хоёр зуун хорин есөн сая есөн зуун наян дөрвөн мянга таван зуун тавин зургаан төгрөг жаран мөнгө/ төгрөгийн төсвийн саналыг Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.
 - 6 аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтын 24,626,386 төгрөгийн барьцааг чөлөөлж, 3 аж ахуйн нэгжийн 19,329,932.18 төгрөгийн барьцааг шинээр бүртгэсэн.
 - Хөрөнгө оруулалтын 3 захирамжаар 4 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, 789,598,643.60 төгрөгийн гэрээг хянаж санхүүжилтийг олгосон.
 - Нэмэлт санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын 2019.01.21-ний өдрийн А/29 дүгээр захирамжаар “Нийслэлийн Орон сууцны корпораци” ХК-ны үйл ажиллагааны зардал 180,000,000.00 төгрөг, “Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ын үйл ажиллагааны зардал 150,980,000.00 төгрөг, “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-ын үйл ажиллагааны зардал 150,000,000.00 төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2018.05.19-ний өдрийн А/44 дүгээр захирамжаар “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент” ХХК-ийн үйл ажиллагааны зардал 70,000,000.00 төгрөгийн санхүүжилтүүдийг батлагдсан хуваарийн дагуу олгосон.
 - Нийслэлийн Засаг даргын 2019.05.22-ны өдрийн А/493 дугаар захирамжаар “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн дүрмийн сангийн 5,0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хянаж олгосон.
 - Урьд онуудын түрээсийн авлагаас 23 иргэн аж ахуй нэгжийн 71,521,900.00 төгрөгийг барагдуулсан. Аудитын албан шаардлагын дагуу “Харднис” ХХК-тай холбоотой түрээсийн 10,667,200.00 төгрөгийн авлагыг 1 дүгээр улирлын тайланд залруулан тайлагнаж авлагад тусган, түрээсийн төлбөрийн өрийг барагдуулсан.
 - Нийслэлийн Хот тохижилтын газар 226,0 сая төгрөг, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас 5,0 сая төгрөгийн ногдол ашиг өрийг барагдуулж төсөвт төвлөрүүлсэн.
 - Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комиссын шийдвэрээр данс бүртгэлээс хасагдсан, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэгдсэн эд хөрөнгийн худалдан борлуулах үнийг тогтоох, борлогдох боломжгүй хөрөнгийг устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөвт төвлөрүүлэх орлого төрөл	Эхний хагас жилийн байлдаар			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Түрээсийн орлого	860,000.00	975,793.2	113%	
2	Өмч хувьчлал	30,800,000.0	-	0%	
3	Ногдол ашиг	100,000.0	283,936.4	284%	
4	Актлагдсан хөрөнгө борлуулсны болон автомашины дуудлага худалдааны орлого	53,500.0	57,482.5	107%	
Дүн		31,813,500.0	1,317,212.0	4%	

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Төсвийн ил тод байдлын талаар:

Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор тус тус батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу мэдээллийг цаг тухай бүр мэдээлэн ажиллаж байна. Үүнд:

<p>Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ –</p> <p>Зарлага: 25,452,283,182.7 төгрөг</p>	<p>Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ –</p> <p>Орлого: 26,112,046,818.82 төгрөг</p>	<p>Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл -</p> <p>20 /тушаал/ 6,920,000.0 төгрөг</p>
--	--	--

№	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Мэдээлэл оруулах давтамж	Нийт мэдээлэх	Мөнгөн дүн	Шийдвэр /гүйлгээ ний тоо
1	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Бүтэн жил	1	-	
2	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Сар бүр	6	-	
3	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Тухай бүр	6		17
4	Дараа жилийн төсвийн төсөл	Бүтэн жил	1	-	
5	Санхүүгийн тайлан	Бүтэн жил	1	-	
6	Санхүүгийн тайлан	Хагас жил	1	-	
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Бүтэн жил	1	-	
8	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Тухай бүр	6	Гэрээний дүн: 6,920,000	20
9	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	Тухай бүр	6	-	
10	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	Тухай бүр	6	-	
11	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	Улирал бүр	2		0
12	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	Тухай бүр	6	-	
13	Худалдан авах ажиллагааны тайлан	Бүтэн жил	1		0
14	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Бүтэн жил	1	Төсөвт өртөг: 0	0
15	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Тухай бүр	6	Батлагдсан төсөвт өртөг: 422,374,725 Гэрээний дүн: 375,235,725.	2

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

16	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	Тухай бүр	12	Орлого: 26,112,046,818.82	209
				Зарлага: 25,452,283,182.7	

3.3.1. Түрээсийн гэрээ байгуулах, орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:

Газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг түрээсийн гэрээний биелэлтийг дүгнэн, 1,034,130,44.0 төгрөгийн үнийн дүн бүхий 341 түрээсийн гэрээ байгуулав.

- ✓ Урт цагаан үйлчилгээний төв - 25
- ✓ Дам түрээс буюу “Өмч эзэмшлийн гэрээ”-гээр эзэмшдэг байгууллагуудын - 122 түрээсийн гэрээ
- ✓ Соёлын төв өргөөний - 35
- ✓ Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн - 35
- ✓ Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд нийт 115 сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулав.

Нийслэлийн өмчийн барилга байгууламжид Түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд:

БЗД-ийн Амгалан цогцолбор сургууль, 142-р сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн сонгон шалгаруулалт болон Өргөө амаржих газар, Нийслэлийн “Хүрээ” амаржих газар, БГД-ийн ЭМТ-ийн Хүүхдийн эмнэлэгийн өвчтөний гал тогооны түрээслэгчийг Сонгон шалгаруулах Ажлын хэсэгт ажиллаа.

3.4. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар:

Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу байгууллагын 65 ажилтан, албан хаагчийн хувийн хэргийг хөтлөн баяжуулалт хийж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын 44 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг ажлын хэсгийн гишүүдтэй хамтран боловсруулж, дагалдах материалын хамт Төрийн албаны зөвлөлд хянуулахаар хүргүүлээ.

Байгууллагын нэр, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын төсөл боловсруулан, мөн хэлтсүүдийн чиг үүргийн өөрчлөлтийг шинэчлэн газрын даргын тушаалаар батлуулав.

Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын дагуу 7 төрийн жинхэнэ албан хаагчид албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг Нийслэлийн Төрийн Албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлээ.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны 8 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгуулсан.

Төрийн албаны мэргэжлийн шалгалтад орж нөөцөд бүртгэгдсэн 4 иргэнийг нөөцөөс сонгох тухай хүсэлт, материалыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн, Нийслэлийн салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэний дагуу томилгоог баталгаажууллаа.

Төрийн албан хаагч бүрийн төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд ажлын цаг ашиглалтыг мөрдөн ажиллахад хяналт тавьж, эмнэлгийн чөлөөтэй 7 /листээр/, захиргааны чөлөөтэй 4, газрын даргын тушаалаар 1 албан хаагчийн чөлөө олгох бүртгэлийг зохих журмын дагуу хөтөллөө.

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Ажилтан, албан хаагчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарийг албан хаагчдын санал, ажлын ачаалал, шаардлагад нийцүүлэн хийж, газрын даргын 2019 оны Б/31 дүгээр тушаалаар батлуулан ээлжийн амралтын мэдэгдлийг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд байгууллагын хүний нөөцтэй холбоотой 17 тушаал батлуулсан байна.

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Ажилд шинээр томилох тухай	2	100%
2	Ажлаас чөлөөлөх	3	100%
3	Цалинг шинэчлэн тогтоох тухай	2	100%
4	Тэтгэмж, тусламж олгох тухай	3	100%
5	Зардал гаргах тухай	3	100%
6	Сахилгын шийтгэл ноогдуулах тухай	1	100%
7	Чөлөө олгох тухай	1	100%
8	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай	1	100%
9	Ур чадварын нэмэгдэл олгох тухай	1	100%
	Нийт	17	100%

3.4.1. “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”, /Сургалт семинар, нийгмийн баталгаа/

Албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зорилгоор 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, “Мэдээллийн цаг”-ийн хуваарийг батлуулсан.

“Мэдээллийн цаг”-аар

- “Байгууллагын эерэг соёл, уур амьсгал бий болгох арга зүй”
- “Ажлын байрны эрүүл, зөв хооллолт” сэдэвт сургалтуудыг зохион байгуулан албан хаагчдыг бүрэн хамруулсан.

Харьяа, дээд байгууллагаас зохион байгуулагдсан сургалтууд:

- Төрийн архивын нөхөн бүрдүүлэлт хийх, байгууллагыг нэгдсэн арга зүйгээр хангах сургалтанд 2019.01.25-ны өдөр архив, бичиг хэгийн ажилтан Т.Азжаргал
- Гадаад хэргийн яамнаас 2019.03.19-ний өдөр зохион байгуулсан Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах сургалтад 2 албан хаагч
- ХХI зууны төрийн албаны менежер сургалтад 2019.03.22-ны өдөр газрын дарга
- ХУД-ын ИТХ-ын хуралдааны танхимд 2019.03.29-ний өдөр зохион байгуулсан “Эрүүл ажлын байр – Эрүүл амьдарлын хэв маяг” сэдэвт сургалтад бичиг хэргийн ажилтан Э.Дөлгөөн
- Удирдлагын академи дээр зохион байгуулагдсан “Төрийн албаны шинэчлэлийн бодлогын үзэл баримтлал” сэдэвт сургалт,
- АТГ, НЗДТГ-аас зохион байгуулсан ХАСХОМ-ийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалт
- НЗДТГ-аас зохион байгуулсан “Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт”-ийн талаарх 2 өдрийн сургалт
- Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах” сургалт
- Нийслэлийн гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтад аюулгүй талбайд түр цуглах дадлагад

- Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх сургалт 2019.06.18-ны өдөр
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар сургалтад 2019.06.19-ны өдөр холбогдох болон ажил хариуцсан албан хаагчид оролцсон.
- Худалдан авах ажиллагааны АЗ сертификатай сургалтанд 4 албан хаагчийг сургасан.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах талаар:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст байгууллагын төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг хүргүүлж, хуулийн үйлчлэлд хамаарах ТЗ-6-аас дээш ангиллын 12 албан хаагчдаас 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг, 1 удаагийн тушаалын дагуу ажлын хэсэгт орсон 3 гишүүнээс “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг авч, дэвшүүлэн томилогдсон 1 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж холбогдох байгууллагаар хянуулан томилууллаа.

Байгууллагын эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн хүрээнд www.meduuleg.iaas.mn программд холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь оруулж тайлагнаж байна.

3.5.Иргэдийн өргөдөл, санал гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл:

Тайлант хугацаанд нийт 24 өргөдөл гомдол ирснийг 100% шийдвэрлэн, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2019 оны эхний хагас жилийн байдлаар 8 хоног 18 цаг 33 минут ба 2018 оны мөн үетэй харьцуулахад 3 хоног 23 цагаар багассан байна. Үүнд:

- Нийслэлийн өмчийн худгийн ашиглалтын талаар тодруулга хүссэн 1
- Дуудлага худалдааны ялагч болсон тухай лавлагаа 1
- Түрээсийн төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлт 1
- Орон сууц хүссэн тухай 1
- Нийслэлийн өмчид шугам сүлжээ бүртгүүлэх хүсэлт 1
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай, худалдаа, үйлчилгээний тухай 7
- Ажлаас чөлөөлөгдөх тухай 1
- Цалинтай чөлөө хүссэн тухай 1
- Архивын лавлагаа мэдээлэл хүссэн тухай 2
- Нийгмийн халамжийн тэтгэмжийн тухай 1
- Цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар, үйлчилгээний тухай 1
- Бусад 5

Хэлтсүүдийн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал:


- ЗСХ 7, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 19 цаг 26 минут
- ӨБХХ 2, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 18 хоног 12 цаг 47 минут
- ӨТМХ 5, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 21 цаг 9 минут
- ӨМХАХ 10, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 цаг 5 хоног 26 минут

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР


Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх оны хагас жилтэй харьцуулбал



Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа



Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг 2019 оны сар бүрээр харьцуулбал:



3.5.1. Ирсэн бичгийн бүртгэл, хяналтын ажлын талаар:

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт EDOC программаар 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1892 албан бичиг ирж бүртгэгдсэнээс хугацаанд нь шийдвэрлэсэн 1634 албан бичиг, судлагдаж байгаа 121 албан бичиг, хугацаа хэтэрсэн 137 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт 94,3%-тай байна.

№	Хэлтэс	Шийдвэрлэлт			Нийт	хувь
		Шийдвэрлэгдсэн	Судлагдаж байгаа	Хугацаа хэтэрсэн		
1	Захиргаа, санхүүгийн хэлтэс	326	18	22	366	96,67%
2	Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтэс	537	9	73	619	93,33%
3	Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс	442	77	37	556	94,33%


НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

4	Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс	329	17	5	351	92,63%
5	Нийт	1634	121	137	1892	94,30%

Ирсэн албан бичгийг графикаар үзүүлбэл:



Албан бичиг шийдвэрлэлтийг өмнөх онуудтай харьцуулбал:




Явуулсан бичгийн шийдвэрлэлтийн тайлан

EDOC программаар нийт 750 албан бичгийг дугаарлан, байгууллагууд руу шилжүүлж, 63 албан бичгийг шуудангийн салбарт хүлээлгэн өгсөн. Албан бичгийн стандарт, хавсралт, хүлээн авах байгууллагын хаягийн бүрэн зөв эсэхийг шалган, тамга, тэмдэг дарах, бүртгэж дугаарлах, дугтуйлах, хаяглах, шуудангийн салбарт хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Явсан бичгийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:



➤ Албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагыг хангуулах ажлын талаар:

Албан бичиг шийдвэрлэлтийн явцад дараах нийтлэг зөрчлүүд гарч, зөрчил арилгуулах арга хэмжээнүүдийг авч ажиллаа.

- Бичгийн гарчиг бичвэрийг жижиг үсгээр эхэлсэн
- Бичгийн товч утгыг буруу бичсэн
- Албан бичгийн стандарт хангаагүй
- Хавсралт материал дутуу зэрэг

Нийт албан хаагчдад 14 хоног тутам шийдвэрлэх хугацаа дөхсөн болон хугацаа хэтэрсэн албан бичгийн жагсаалтыг гарган, танилцуулж, гарын үсгээр баталгаажуулан хугацаандаа шийдвэрлэхийг мэдэгдэн ажиллаж байна.

Бусад байгууллагаас ирсэн үндсэн үйл ажиллагаатай холбоотой албан бичгийн бүрдэлд хяналт тавин 86 албан бичгийн зөрчлийг бүртгэн тухайн байгууллагад нь мэдэгдсэн.

Байгууллагын хэрэгцээнд эхний хагас жилийн байдлаар А4-2000 ш, А5-2000 ш, тушаал-2000 ш, албан даалгаврын -100 ш албан бланкийг EDOC программаар захиалан, нийт 892 ширхэг бланк албан хаагчдад хүлээлгэн өгснөөс А4-95, А5-43, Тушаал-95 ширхэгийг хүчингүй болгож, 14,715 төгрөгийн тооцоог гаргалаа.

3.6.Захиалагчийн хяналт тавьж ажилласан ажлын талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хууль тогтоомжийн дагуу 6 төсөл арга хэмжээний ажил үйлчилгээ нийлүүлэх гэрээ байгуулан захиалагчийн хяналт тавьж ажиллаа. Үүнд:

1. Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/76 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан “Сургуулийн автобус төсөл” НХААГ-18/0004-3 дугаартай сургуулийн автобус нийлүүлэх тендерт шалгарсан “Жэй Ти Эс Эс” ХХК-тай 2019.03.12-ны өдөр гэрээ байгуулан НЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсээр 2019.03.20-ны өдөр баталгаажуулсан.
2. НЗД-ын 2018 оны “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/652 дугаар захирамжийн дагуу нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан “Чигнэлтэй дүүрэгт хог хаягдал тээвэрлэх зориулалт бүхий автомашин нийлүүлэх” НХААГ/18/0072-2 дугаартай тендерт шалгарсан “Гоёлтан” ХХК-тай гэрээ байгуулан захиалагчийн хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэв.
3. НЗД-ын 2018 оны “Эрх шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Эко эрин тохижилт” ХХК-тай 115,5 сая төгрөгийн өртөг бүхий “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалттай 7 төрлийн гар багаж, /5 ком/ нийлүүлэх ажил” НБ/2019-02 дугаартай гэрээ байгуулан батлуулахаар НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэстхүргүүлэв.

4. НЗД-ын 2018 оны “Эрх шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу “Зана констракшн” ХХК-тай 232,2 сая төгрөгийн өртөг бүхий “Мод сөөг хэлбэржүүлэх зориулалтын бага оврын авто өргөгчтэй машин /автовишка 3 ширхэг/-ийг нийлүүлэх ажил” НБ/2019-01 дугаартай гэрээ байгуулан, батлуулахаар НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.
5. НЗД-ын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/248 дугаар захирамжаар Багануур дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/93 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн “Смарт-энтерпрайз” ХХК-тай байгуулсан “Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобус /2ш/ нийлүүлэх ажил” ЗТХЯ/201901008 дугаартай гэрээ байгуулан батлуулав. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны 06 сарын 14-ний өдрийн А/156 дугаар тушаалаар нийлүүлэгдэж буй хөрөнгийг нийслэлийн өмчид хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулж, Багануур дүүрэгт нийлүүлэгдэж буй нийтийн тээврийн автобус /2ш/-ыг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу актаар хүлээн авах ажлыг зохион байгуулахыг даалгаад байна.
6. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/423, А/424, А/428 дугаар захирамжийн дагуу манай газарт захиалагчийн хяналт тавьж ажиллахыг даалгасан бөгөөд НӨАУГ-ын 2019 оны 2/567, 2/598, 2/597, 2/599 тоот албан бичгээр техникийн тодорхойлолтыг ирүүлэхийг тухайн байгууллагуудад мэдэгдсэн.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих төсөл арга хэмжээнүүдээс нийслэлийн Засаг даргын 2019.04.04-ны өдрийн А/262 дугаар захирамжаар Баянгол дүүргийн 3 дугаар хороо, Нарны хороололд “960 хүүхдийн ерөнхий боловсролын сургууль, 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, гадна инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажлын хамт худалдан авах” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг манай газарт шилжүүлсэн. Энэхүү захирамжийн дагуу Газрын даргын 2019.05.21-ний өдрийн А/120 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан.

Үнэлгээний хорооны 2019.05.22-ны өдрийн хурлаар бараа нийлүүлэх тендерийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай Баянгол дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Нарны хороолол”-д “Гранд слаб” ХХК-ийн барьсан иж бүрэн тоног төхөөрөмж бүхий 960 хүүхдийн суудалтай сургууль, 280 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тохижилт, тоног төхөөрөмжид хийсэн эрх бүхий хөндлөнгийн байгууллагын үнэлгээний тайланг ирүүлэх тухай албан бичгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд хүргүүлэх, ажлын тоо хэмжээг нарийвчлан боловсруулж ирүүлэхийг нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Боловсролын газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2019.05.22-ны өдрийн 3/592, 3/593 дугаар албан бичгүүдийг холбогдох газарт хүргүүлээд байна.

3.7. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлсэн талаар:

Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлого, нийслэлийн өмчид бүртгэсэн хөрөнгө, хөрөнгө илүүдэлтэй байгууллагаас дутагдалтай байгууллагад балансаас балансад шилжүүлсэн ажлуудын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг 4 жилийн байдлаар тайлант хугацаагаар харьцуулбал:


НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ОРЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

МЯН.ТӨВ



Үзүүлэлтийн тэмүүлэл
Тайлагналын давтамж
Мэдээллийн эх үүсвэр
Үзүүлэлтийн хүчин зүйлс

Өсөхдөө сайн
Сар бүр
Төрийн сангийн харилцахын данс
- 2018 онд Усан спортын сургалтын төвийн байрыг хувьчилсан

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ТҮРЭЭСИЙН ОРЛОГО

МЯН.ТӨВ




Үзүүлэлтийн тэмүүлэл
Тайлагналын давтамж
Мэдээллийн эх үүсвэр
Үзүүлэлтийн хүчин зүйлс

Өсөхдөө сайн
Сар бүр
Төрийн сангийн харилцахын данс
- 2019 оны түрээсийн орлого өссөн нь НИТХТ-ын 2018 оны 40 дүгээр тогтоолоор түрээсийн төлбөрийн доод жилийг үнийг шинэчлэн тогтоосон тарифаар тооцсон.

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШГИЙН ОРЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

МНЭ 7962



Үзүүлэлтийн тэмүүлэл
Тайлагналын давтамж
Мэдээллийн эх үүсвэр
Үзүүлэлтийн хүчлэг зүйлс

Өсөхдөө сайн
Сар бүр
Төрийн сангийн хариуцахын дэвс
- 2019 онд НХОГ- 5 сая, ХТГ-226, Далайн захиргаа /20 мян. ам.доллар/ 32 сая төгрөг төвлөрүүлсэн

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ АКТЛАГДСАН ХӨРӨНГӨ, БОРЛУУЛАЛСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЛИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ОРЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

МНЭ 7962




Үзүүлэлтийн тэмүүлэл
Тайлагналын давтамж
Мэдээллийн эх үүсвэр
Үзүүлэлтийн хүчлэг зүйлс

Өсөхдөө сайн
Сар бүр
Төрийн сангийн хариуцахын дэвс
- 2018 оноос буурсан нь татан төвлөрүүлсэн хөрөнгө багассан

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

УЛС, НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БУСАД ТӨРТИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР БИЙ БОЛСОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГААС НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

АЛМН 1768




Үзүүлэлтийн тэмдүүлэл
Тайлангалын давтамж
Мэдээллийн эх үүсвэр
Үзүүлэлтийн хүчин зүйлс

Саяо бүр
Нийслэлийн Засаг даргын захиралж, /2016 онд НИТХ-ын тогтоолоор барилга байгууламж бүртгэсэн/
Захиалагч байгууллагаас ирүүлсэн хувиалт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН, ХУДАЛДАН АВСАН ХӨРӨНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

2018.09.25

АЛМН 1769




НӨХТ-ийн ЗБХХХХ-ийн хурал



Нийт шинээр бий болсон хөрөнгийн дүн




Худалдан авах зөвшөөрөл олгосон хөрөнгийн дүн



НИТХ-ын тогтоол, НЭД-ын захирамж


Захиалагч байгууллагаас нийслэлийн өмчид бүртгүүлсэн барилга байгууламж, тээврийн хэрэгслийн дүн




ЗБХХХХ-ийн хөрөнгийн хөдөлгөөний дүн



НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР





**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:
”БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДАЛ”**

4.1. Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох стратегийн зорилтын хүрээнд:

Төрийн үйлчилгээ, мэдээ мэдээллийг түгээх, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээ мэдээлэл хүргэх, үйл ажиллагааг зохицуулах зорилтын хүрээнд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоол “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг байгууллагын цахим хуудасны үйл ажиллагаанд мөрдлөг болгон үндсэн үйл ажиллагаатай холбоотой болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулагдаж буй ажлуудын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулж байна.

Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээллүүдийг тухай бүр байршуулж байна:

1. Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 142 дугаар сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цайны газрын түрээслэгчийн сонгон шалгаруулалтын урилга;
2. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмнэлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг түрээслүүлэх сонгон шалгаруулалтын зар

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

3. Тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны зар болон зохион байгуулсан талаарх мэдээ
4. Багануур дүүргийн эрүүл мэндийн төвийн байранд үйлчилгээ эрхлэх түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай
5. “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”, “Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан санал авах тухай;
6. Байгууллагын харьяаллын 250 гаруй ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн талаар;
7. Нийслэлийн 34 агентлагийн 7 хоногт хийсэн томоохон ажлуудын тойм мэдээ
8. Сонгон шалгаруулалтын урилга

Үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны А тушаал 168, байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой гарсан НИТХТ-ийн 19 тогтоол;
2. 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол "Дүрэм батлах тухай" /Тогтоолын хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"/;
3. Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл
4. Албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ
5. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ
6. Төсөв санхүүгийн ил тод байдал
 - 2019 оны төсвийн төсөл
 - 2019 оны төсвийн орлого зарлагын гүйцэтгэлийн мэдээ /5 сар хүртэл/,
 - 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
 - Аудитын дүгнэлт
7. ЗГ-ын 2019 оны 100 дугаар тогтоолоор байгууллагын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан цахим хуудсанд хийсэн шинэчлэл:
 - Цахим хуудасны нэр, лого
 - Бүтэц орон тооны схем
 - Хэлтсүүдийн нэр, чиг үүрэг
 - Холбоо барих утасны жагсаалтыг тус тус шинэчлэн байршууллаа.

4.2. Хууль шүүхийн байгууллагад төлөөлөх ажлын талаар:

Тайлант хугацаанд анхан шатны шүүхэд хянагдаж байгаа 13, давж заалдах шатны шүүхэд 2 хэрэг хянагдаж байна.

“Анома” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд болон НӨАУГ-т холбогдолтой хэргийн Захиргааны хэргийн шүүхэд гаргасан гомдлын дагуу дээд шүүхэд давж заалдахаар нэхэмжлэл гаргасан ба Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 06 дугаар магадлалтай “Анома” ХХК-ийн нэхэмжлэлтэй дээд шүүхийн хурал 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдөр хуралдаж, Иргэний хэргийн анхан шатны шүүхэд дахин хянуулахаар буцсан болно.

“Эрдэнэсуварга” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргад холбогдох маргаан бүхий захиргааны хэргийг 2019.02.19-ны өдрийн шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.14-т заасны дагуу нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Анхан шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн мэдээ

№	Нэхэмжлэгч	Хариу цагч	Гуравдагч этгээд	Нэхэмжлэлийн утга	Тайлбар
1	Б.Тэрбиш	НЗД, НӨАУГ	-	Газрын маргаан	ЧД-ийн ИХАШШ

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2	Мах экспорт ХХК	НЗД		Газрын маргаан	НЗХАШШ
3	Б.Пүрэвдорж	НӨАУГ, НХТЕТГ БГД-ийн ЗД		Газрын маргаан	НЗХАШШ
4	Мичид Энержи ХХК	ЗАА-ны ХИХУГ		Тоног төхөөрөмжийн 170,4 сая төгрөг	ХУД-ийн ИХАШШ
5	Тэлмэн констракшн ХХК	НӨАУГ, Налайх Дулаан ТӨХК		Хохирол 35,0 төгрөг гаргуулах	НЗХАШШ
6	Н.Баасанжав “Хайрхан – Уул Өргөө” ХХК	НӨАУГ		Дэнчин 24,6 сая төгрөг гаргуулах	СБД-ийн шүүх
7	Анома ХХК	НИТХ, НӨАУГ		3,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг гаргуулах	ЧД-ийн шүүх
8	ЗТХЯ, НӨАУГ, НТҮГ	Зорчигч тээврийн нэгтгэл		14,1 сая төгрөг автобусны төлбөр	ХУД-ийн шүүх
9	ЗТХЯ, НӨАУГ, НТҮГ	Сутайн буянт ХХК		30 автобусны төлбөр	СХД-ийн шүүх
10	ЗТХЯ, НӨАУГ, НТҮГ	Автобус нэгдэл ХХК		10 автобус	СХД-ийн шүүх
11	ЗТХЯ, НӨАУГ, НТҮГ	Мяралзаа ХХК		8 автобус	БЗД-ийн шүүх
12	ЗТХЯ, НӨАУГ, НТҮГ	Тэнүүн огоо ХХК		50 автобус	БГД-ийн шүүх
13	ЗТХЯ, НӨАУГ, НТҮГ	Эрдэм транс ХХК		30 автобус	БГД-ийн шүүх

Давж заалдах шатны шүүхэд хянагдаж байгаа хэргийн мэдээ

№	Нэхэмжлэгч	Хариуцагч	Гуравдагч этгээд	Нэхэмжлэлийн утга	Тайлбар
1	ЧД-ийн Нийгмийн даатгал	НӨАУГ	-	Нийгмийн даатгалын төлбөр 33,0 сая төгрөг	ЧД-ийн ИХАШШ-ийн 2019.04.22-нд 11,0 сая төгрөгийг чөлөөлж 22,0 сая төгрөгийг НӨАУГ-аас гаргуулав.
2	Эрдэнэ суврага ХХК	НЗД, НӨАУГ		Өмч хөрөнгийн өрийн асуудал	НЗХАШШ-ээр нэхэмжлэлийг хянаж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

5.1.Нийслэлийн төсөвт байгууллагууд, НӨҮГ-ууд болон бусад байгууллагуудад хийж хэрэгжүүлсэн ажил

1. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газрууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай” А/09 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2019 оны 01 дүгээр сарын 07-17-ны хооронд нийслэлийн төсөвт 18 байгууллагад ажилласан.

2. НЗД-ын 2018 оны 913 дугаар захирамжийн дагуу Япон улсын “Эм Ай Эс” ХК-иас УБТЗ-ын зорчигчийн вагоны галлагааны зуухнаас гарах утааг бууруулах дэвшилтэт тоног төхөөрөмж

нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын комисст ӨБХХ-ийн ахлах мэргэжилтэн С.Ариунжаргал орж ажилласан.

3. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/1033 дугаар захирамжаар байгуулагдсан нийслэлийн Зөвлөлийн дэргэдэх Үнэлгээний комисст холбогдох мэргэжилтнүүд ажиллан дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Нийслэлийн Зөвлөлийн дэргэдэх Худалдан борлуулах комисст 2019.02.19-ний өдрийн 07/542 тоот албан бичгээр СХД-ийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн хураасан 3,060,000 төгрөгийн хөрөнгийг устгах саналыг хүргүүлсэн.
- Нийслэлийн Зөвлөлийн хурлаас шийдвэрлэсний дагуу Нийслэлийн Онцгой байдлын газарт 2019.02.19-ний өдрийн 07/543 тоот албан бичгээр 304 хайрцаг утаат тамхийг 1,116,600 төгрөгөөр үнэлж хүргүүлсэн.
- Нийслэлийн Зөвлөлийн дэргэдэх Үнэлгээний комиссын гишүүд 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр газар дээр нь буюу Туушин, УБТЗ-ын АБТЭМА, Прогресс Транс, Интер десижн, Гермес гэсэн гаалийн хяналтын 5 бүсэд хураагдсан хөрөнгийн байдалтай танилцан, УБ хот дахь Гаалийн газрын хураагдсан 7ш автомашин, 4ш автомашины кузовын үнэлгээг тогтоолоо.

4. НЗД-ын 2019 оны Б/39, Б/59 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын даргын ажил хүлээлцэх комисст ажиллан, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга тэмдэг, Хас, Улаанбаатар хотын, Голомт, Хаан банкны харилцахын үлдэгдэл, 2,922.2 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө, 922,1 сая төгрөгийн бараа материал, 2,326.0 сая төгрөгийн авлага, 6,348.6 сая төгрөгийн өглөгийг актаар хүлээлгэн өгч баталгаажуулсан.

5. Засгийн газрын 2018 оны Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоол, Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд НӨХГ-ын даргын 2018 оны А/578 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсэг нийт 41 сургууль, цэцэрлэгийн 83 халаалтын зуухны үйл ажиллагаатай танилцан, тайланг 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр УБ хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хурал, 2019.03.07-ны өдөр НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, НЗД-ын 2019 оны А/487 дугаар захирамжаар СХД, БЗД, СБД, ЧД, ХУД-ийн нутаг дэвсгэрт байрлах 12 сургууль, 2 цэцэрлэгийн хөрөнгөд бүртгэлтэй халаалтын зуух, тоног төхөөрөмжийг “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

6. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах” хууль тогтоомжийн дагуу орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын бараа ажил үйлчилгээ худалдан авах 55 үнэлгээний хороонд холбогдох албан хаагчид санал, дүгнэлтээ өгч ажилласан.

7. “Улаанбаатар сан” ОНӨААТҮГ-ыг татан буулгах шийдвэр 2015 онд гарсан боловч тухайн үед хаалтын баланс гаргаагүй. Иймд Нийслэлийн Архивын газраас санхүүгийн баримтыг татан авч Нийслэлийн Татварын газарт хүргүүлэн, шалгалт оруулаад байна.

8. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/76 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулагдсан “Сургуулийн автобус төсөл”-ийн автобус нийлүүлэх ажлын хүрээнд “Сургуулийн автобус нийлүүлэх гэрээ”-ний дагуу автобуснуудыг нийслэлийн өмчид хүлээн авах ажлыг зохион байгуулах “Ажлын хэсэг байгуулах тухай” Нийслэлийн Өмчийн Ашиглалт, Удирдлагын газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/106 дугаар тушаал гаргав. “Жи Ти Эс Эс” ХХК-иас ирүүлсэн “Сургуулийн автобус нийлүүлэх гэрээ”-ний хугацаа сунгуулах хүсэлт ирүүлснийг судалж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тус автобуснуудыг хүлээн авах 3 сургуулийн удирдлагуудын хамт үйлдвэрлэлийн байдалтай газар дээр нь очиж танилцан холбогдох саналуудыг өгөв.

9. “Улаанбаатар хотын Гэр хорооллыг Хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-өөс ирүүлсэн Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баригдаж байгаа 4 барилгын ашиглагч байгууллагыг тодорхойлох асуудлыг судалж, НЗД-ын 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн “Ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагыг тодорхойлох тухай” А/455 дугаар захирамж гаргуулсан. Бизнес инкубатор төв, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн

төвийн барилгын “Барилга ашиглалтад хүлээн авах комисс” 2019.05.24-ний өдөр ажилласан бөгөөд НХОГ-аас холбогдох материалыг ирүүлээгүй байна.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Баянхошуу дэд төвд баригдсан Бизнес инкубатор төв, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах, Ашиглалтын захиргаа байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл, танилцуулгыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсийн дарга нараас санал авсан. Одоогийн байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид танилцуулагдаж байна. НЗД-ын захирамж гарсны дараа Ашиглалтын захиргаанд барилгыг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах болно.

10. Засгийн Газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын дагуу сайжруулсан түлшийг хадгалах, нөөцлөх зориулалтаар бага дунд оврын агуулахуудыг барьж байгуулах ажлын хүрээнд эзэмших, өмчлөх эрх бүхий газраа нийслэлийн газрын санд шилжүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн газар эзэмших, өмчлөх эрх дуусгавар болсон 107 байршилд буй газруудыг Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Газар эзэмших эрх олгох тухай” А/287 дугаар захирамжаар нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газарт газар эзэмших эрх олгосон байна.

Дээрх 107 байршилд буй газруудыг хүлээн авах Ажлын хэсгийг НӨАУГ-ын даргын 2019 оны А/78 дугаар тушаалаар томилон, сайжруулсан түлшийг хадгалах, нөөцлөх, худалдан борлуулах зориулалтаар Сонгинохайрхан дүүрэгт 59, Сүхбаатар дүүрэгт 18, Чингэлтэй дүүрэгт 16, Баянзүрх дүүрэгт 14 байршил нийт 4 дүүргийн 107 байршилд байрлуулах ажлыг зохион байгуулсан.

“Таван толгой түлш” ХХК-ны үйлдвэрлэж байгаа сайжруулсан шахмал түлшийг “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар”-ын эзэмшлийн 107 байршлаар дамжуулж нөөцлөлт хийж борлуулах зорилгоор 2019.05.23-ны өдөр Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ч.Однасан, “Таван толгой түлш” ХХК-ний захирал С.Ганбаатар нар нь № ТТТ2019 дугаартай “Хамтран ажиллах” гэрээг байгуулсан.

Гэрээний дагуу 4 дүүргийн 107 байршил дахь газруудыг “Таван толгой түлш” ХХК-д хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулан, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2019.05.13-ны өдрийн 4/547 тоот албан бичгээр 107 байршилд байрлах газруудын газар эзэмших гэрчилгээг НӨАУГ-т олгох хүсэлтийг хүргүүлээд байна.

5.2. Хяналт, шинжилгээ үнэлгээний ажлын талаар:

5.2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн талаар:

Тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2019 оны нэгдүгээр улирал, эхний хагас жилийн байдлаар дүн шинжилгээ хийж, байгууллагын Удирдлагын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан, хариуцсан хэлтсүүдэд үүрэг болгон, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:

- Нэгдүгээр улирлын байдлаар:
 - Ерөнхийлөгчийн зарлиг 1 - 100%
 - Засгийн газрын тогтоол 1- 100%
 - Засгийн газрын журам 3 - 90%
 - Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 3- 97%
 - НИТХТ-ийн тогтоол 7- 81%
 - НИТХ-ын тэмдэглэл 1 - 100%
 - Нийслэлийн Засаг даргын захирамж 24- 97%
 - НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл 2- 100%

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

Дээрх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 71 заалтаас хэрэгжих шатанд 4, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 4, хэрэгжилт хангалтгүй 1, үнэлэх боломжгүй 2 заалт байсан бөгөөд тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулсан. Үүнд:

- Тайлант хугацаанд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн нийт 71 заалтаас хэрэгжих шатанд 4, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 4, хэрэгжилт хангалтгүй 1, үнэлэх боломжгүй 2 заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж тайлант хугацаанд хэрэгжилт нь бүрэн хангаагүй, дутуу хэрэгжсэн ажлын хэрэгжилтийг дахин гаргах,
- Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан журамд баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг дээд шатны байгууллагад тайлагнах хугацааг тогтоосон ба хэлтсүүд холбогдох биелэлтийг заасан хугацаанаас ажлын 3 хоногийн өмнө Захиргаа, санхүүгийн хэлтэст хүргэж хэвших,
- Хэлтсүүд мэдээ тайлангийн үнэн бодит байдлыг хангаж, харьцуулсан тоон мэдээлэлд үндэслэн хүрсэн үр дүнг хүрэх түвшинтэй уялдуулан товч бөгөөд тодорхой, шаардлагатай мэдээлэл бүхий байдлаар боловсруулан гаргах,
- Хөрөнгө оруулалт, бүртгэлтэй холбоотой гадаад хүчин зүйлээс шалтгаалан үнэлэх боломжгүй ажлын явцыг тухайн байгууллагаас тодруулж мэдээ, тайланд тусгах

➤ Эхний хагас жилийн байдлаар:

- Засгийн газрын тогтоол	4	96.25%
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	75.57%
- НИТХТ-ын тогтоол	13	80.77%
- НИТХТ-ын хурлын тэмдэглэл	3	73.33%

Үүнээс:

- Бүрэн хэрэгжсэн /90%-100%/	37 заалт
- Хэрэгжих шатанд /50%-89%/	11 заалт
- Хэрэгжилт хангалтгүй /10%-49%/	1 заалт
- Үнэлэх боломжгүй	1 заалт
- Удааширсан	ЗГХТ 2019 оны 03-1
- Тасарсан	ЗГХТ 2018 оны №25

Нийслэлийн Засаг даргын нийт 38 захирамжийн хэрэгжилтийг харуулбал:

- Бүрэн хэрэгжсэн /90%-100%/	33
- Хэрэгжих шатанд /50%-89%/	5

5.2.2. Хяналт шалгалтын ажлын талаар:

Эрүүгийн цагдаагийн албанаас байгуулсан "АСЕМ"-ын хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон бүтээн байгуулалтын нийт 34,067,200,000 төгрөгийн хөрөнгийг газар дээр нь очиж шалгах болон материалтай танилцах ажлын хэсэгт 2018.12.15-ны өдрөөс ажиллан УСУГ-ын харьяа Төв цэвэрлэх байгууламж, Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын балансад бүртгэлтэй шинээр бий болсон 3 авто замыг газар дээр нь очиж танилцан шалгалт хийсэн.

БЗД-ийн Амгалан цогцолбор сургууль, 142-р сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрийн сонгон шалгаруулалт болон Өргөө амаржих газар, БГД-ийн ЭМН-ийн хүүхдийн эмнэлгийн цайны газрын түрээслэгч сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж хяналт тавин ажилласан бөгөөд ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна.

Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, нийслэлийн өмчит байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо төрөл нормативт хяналт тавих замаар төсвийн зардлыг бууруулах арга хэмжээ авах ажлын хүрээнд нийслэлийн 301 байгууллагын

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

163,296.1 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2231 тээврийн хэрэгслийн нарийвчилсан судалгааг гаргаж автомашины тоо төрөл, үнэлгээ, автомашинтай холбоотой гарсан зардлын судалгааг хийж тээврийн хэрэгсэлд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

Нийслэлийн хэмжээнд дутагдуулсан болон маргаантай байгаа барилга байгууламжийн судалгааг гаргасан. Үүнд:

- Нийслэлийн өмчит 28 хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй 167 нэр төрлийн 11,230.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан. Дутагдсан хөрөнгийг нэр төрлийн хувьд авч үзвэл 1,8 хувь нь барилга, 0,1 хувь нь шугам сүлжээ, 98,1 хувь нь нийтийн эзэмшлийн эд хөрөнгө
- Маргаантай хөрөнгийн нэгтгэлд 17 хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй 74 нэрийн 1 212,9 сая төгрөгийн дахин үнэлгээ хийгдээгүй хөрөнгө байна.

БЗД-ийн 4-р хороонд байрлах “Бүтэн өнчин хүүхдүүдийн хөгжил сан”-ын барилгыг 2019.05.13-ны өдөр газар дээр нь очиж шалгахад, уг барилгад үйл ажиллагаа явуулаагүй цоожтой байгаа бөгөөд ТББ-ын тэргүүн Батдоржтой цаашид авах арга хэмжээний талаар уулзаж ярилцахыг мэдэгдсэн.

СБД-ийн Сувиллын эмнэлгийн түрээслэгч гэрээгээ цуцлуулах хүсэлт ирүүлсний дагуу тус эмнэлгийн цайны газрын талбайн хэмжилтийг хийж дараагийн сонгон шалгаруулатын зарыг байгууллагын цахим хуудас, СБД-ийн ЭМТ-ийн цахим хуудсанд байршуулсан.

БГД-ийн 8-р хороонд байрлах “Аминжаргалан” ӨЭМТ-ийн ашиглалтгүй байгаа байрыг дараагийн үйл ажиллагаанд ашиглах талаар удирдлагад танилцуусан.

Нийслэлийн ахмадын хороо ашиглаж буй ЧД-ийн 5-р хорооны нутаг дэвсгэрт байрлах 6-р байрын 1-р давхрын 23 м² талбайтай 1 өрөөг 2019 оны 06 дугаар сарын 03-ын өдөр чөлөөлөн, дараагийн түрээслэгчтэй шууд түрээсийн гэрээг байгуулсан.

Нийслэлийн өмчит байгууллагуудад НӨАУГ-ын 2019.06.04-ний өдрийн 4/669 тоот албан бичгээр барилгын төлөв, чанар байдлын судалгаа авах тухай мэдэгдэн, дүүргүүдээс судалгааг авч нэгтгэсэн.

Нийслэлийн өмчид бүртгэлтэй 3187 барилга байгууламжийн техникийн баримт бичгийг бүрдүүлэн, улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх, барилгын хувийн хэрэг хөтөлж, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж зориулалтын дагуу ашиглаж буй зэрэгт хяналт тавих ажлыг эхлүүлээд байна.

5.2.3. Архивын ажлын талаар:

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн архивын баримт материал, хадгаламжийн нэгжүүдийн эмх цэгцийг ханган ажиллах ажлын хүрээнд архивын баримтыг ирүүлэх тухай 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Газрын даргын 01 дүгээр албан даалгавраар хуваарь батлуулсан, 2019.01.23 – 2019.02.13-ны өдрийн хооронд албан хаагчдаас архивын хадгаламжийн нэгжүүдийг архивт хүлээн авсан.



✓ 70 жил хадгалах - 9, Байнга хадгалах - 138, Түр хадгалах - 68 баримт

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

№	Баримтын төрөл	Баримтын хязгаар	Баримтын тоо	Тайлбар
1	Байнга хадгалах хадгаламжийн нэгж	2004- 2010	1188 ХН	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримтууд
2	Түр хадгалах хадгаламжийн нэгж	1999 – 2014	1401 ХН	Ирсэн, явсан бичиг, харилцахын баримт
3	70 жил хадгалах хадгаламжийн нэгж	1991-2018	30 ХН	Газрын даргын “Б” тушаал, санхүүгийн баримт /нийгмийн даатгал/
4	Нийт	1991-2018	2619 ХН	Хадгаламжийн нэгж

Мөн 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний 148 ширхэг баримтуудыг стандарт, журмын дагуу бүртгэл хөтлөн хүлээн авсан.

Архивын нөхөн бүрдүүлэлт хийхтэй холбоотойгоор Нийслэлийн Архивын газартай нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах 2019-26 дугаартай гэрээг 2019.02.15-ны өдөр байгуулан газрын даргын А/27 дугаар тушаалаар архивын нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийслэлийн Архивын газартай байгуулсан “Нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах тухай гэрээний дагуу хадгаламжийн нэгжүүдэд иж бүрэн тооллого, нягтлан шалгалтыг хийсэн.

➤ *Байнга хадгалах хадгаламжийн нэгжүүдэд нөхөн бүрдүүлэлт хийсэн байдал:*

- 2004-2010 оны байнга хадгалах нийт 1188 хадгаламжийн нэгжийг тоолон, нягтлан шалгаж бүртгэлтэй тулгалт хийсэн. /2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар батлагдсан/
- Алга болсон нийт 49 хадгаламжийн нэгжүүдэд баримт эрэн сурвалжлах үйл ажиллагаа явуулж нийт 31 хадгаламжийн нэгжийг олсон.
- 2011-2014 оны газрын даргын 36 ширхэг тушаалын ботиудыг цахим хэлбэрт оруулан хадгалсан.
- 1997-2000 оны нийт Өмч хувьчлалын хэлтсийн байнга хадгалах 120 хадгаламжийн нэгжийг тоолон, нягтлан шалгаж бүртгэлтэй тулгалт хийсэн. /Нийслэлийн БНШАЗК-ын 2000 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар батлагдсан/
- 2011-2014 оны байнга хадгалах нийт 816 хадгаламжийн нэгжийг төрийн архивт шилжүүлэхээр баримт бүрт нягтлан шалгалт хийсэн.
- 2015-2018 оны байнга хадгалах 860 хадгаламжийн нэгжийг шинээр дугаарлан бүртгэл үйлдсэн.
- 2011-2014 оны Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба руу шилжүүлэх 101 хадгаламжийн нэгжийг бүртгэн нягтлан шалгалт хийсэн.

➤ *Түр хадгалах хадгаламжийн нэгжүүдэд нөхөн бүрдүүлэлт хийсэн байдал:*

- 1999-2014 оны түр хадгалах 1401 хадгаламжийн нэгжийг тус бүрээр нь тоолон нягтлан шалгаж, батлагдсан бүртгэлтэй тулгалт хийсэн.
- 1999-2014 оны хөтлөх нэрийн жагсаалтын дагуу хугацаа дууссан 326 хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдсэн.

➤ *70 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдэд нөхөн бүрдүүлэлт хийсэн байдал:*

- 1991-2010 оны нийт 56 байгууллагад 70 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдийг тус бүрээр нь тоолон нягтлан шалгалт хийж , батлагдсан бүртгэлтэй тулгалт хийсэн.

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- 2011-2018 оны 28 байгууллагад 70 жил хадгалах хадгаламжийн нэгжүүдэд нягтлан шалгалт хийсэн.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/117 дугаар тушаалаар “Байгууллагын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комисс”-ыг шинэчлэн байгуулсан.

Байгууллагын дэргэдэх “Баримт бичиг нягтлан шалгах комисс” 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хуралдан Нийслэлийн Архивын газрын мэргэжилтэн Х.Бямбасүрэн, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн Ц.Дунгармаа нар ирж санал, зөвлөмж өгсөн.

Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах Төв комиссын бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” 46 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Нийслэлийн хэмжээнд Төрийн байгууллагын ажлыг зохион байгуулах тухай” А/518 дугаар захирамж тус тус батлагдан гарсантай холбогдуулан зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдсан. Үүнд:

- Архивын Улсын үзлэг явуулах тухай 2019.05.14-ний өдрийн сургалт
- Архивын Ерөнхий газраас “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх чиглэл” сургалт 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр
- Нийслэлийн Архивын газрын “Улсын үзлэгийн бэлтгэл зохион байгуулалтыг хангуулах, мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөх зорилгоор Нийслэлийн Засаг даргын баталсан хөтөлбөр, хуваарийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдсан.

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын тушаалын биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд газрын даргын 2 албан даалгавар, 207 тушаал гарснаас “А” буюу хөрөнгө бүртгэн авах, балансаас балансад шилжүүлэх, данснаас дансанд шилжүүлэх, данснаас хасах зэрэг үндсэн чиг үүргийн дагуу 169 тушаал, “Б” буюу хүний нөөцийн чиглэлээр 38 тушаал гаргаж, хэвлэмэл хуудсанд ёсчлох ажлыг хийж гүйцэтгэлээ. Хэрэгжилт 100%-ийн биелэлттэй байна.

А-тушаал

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Эргэлтийн бус хөрөнгө данснаас хасах тухай	88	100%
2	Эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай	30	100%
3	Ажлын хэсэг байгуулах тухай	19	100%
4	Эргэлтийн бус хөрөнгө данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай	21	100%
5	Загвар батлах тухай	2	100%
6	Зардал гаргах, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай	5	100%
7	Хариуцлагатай жижүүр, эргүүл томилон ажиллуулах тухай	1	100%
8	Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай	1	100%
9	Хоолны зардал шинэчлэн тогтоох тухай	1	100%
10	Гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах тухай	2	100%
	Нийт	169	100%

Б-тушаал

№	Тушаалын нэр	Тоо	Биелэлт
1	Ажилд шинээр томилх тухай	6	100%

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

2	Ажлаас чөлөөлөх тухай	4	100%
3	Цалинг шинэчлэн тогтоох тухай	19	100%
4	Тэтгэмж, тусламж олгох тухай	11	100%
5	Зардал гаргах тухай	3	100%
6	Сахилгын шийтгэл ногдуулах тухай	1	100%
7	Чөлөө олгох тухай	3	100%
8	Ээлжийн амралтын хуваарь батлах тухай	2	100%
9	Албан хаагчийг шилжүүлэн ажлуулах тухай	6	100%
	Нийт	38	100%

Дотоод ажлын талаар:

- Билгийн тооллын хаврын тэргүүн сарын Цагаан сарын баярыг тохиолдуулан байгууллагын харьяалалд бүртгэлтэй ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг олгох ажлыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан.
- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын зөвлөгөөн 2019.01.25-ны өдөр Соёлын төв өргөөны танхимд болж байгууллагын 20 төрийн албан хаагч
- Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу 2019.05.18-ны өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар-2019” олон улсын марафон гүйлтийн тэмцээн
- ННЗБ-уудын захиргааны хэлтсийн дарга болон хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан уулзалт
- Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 сарын 11-ний өдрийн “Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай” А/285 дугаар захирамжийн хүрээнд, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/99 дүгээр тушаалаар зохион байгуулсан “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээнд байгууллагын албан хаагчид Хан-Уул дүүргийн UB town хотхоноос Хөрш заан хотхон хүртэл туул голын эргэ дагуух газрыг цэвэрлэн, 25 шуудай хог хаягдлыг НЗАА-д хүлээлгэн өгч нийтийн их цэвэрлэгээний арга хэмжээнд оролцсон.
- Улаанбаатар хотын захирагчийн тушаалаар зохион байгуулагдсан "Өгөөмөр өдөр" өдөрлөгт байгууллагын албан хаагчдын цуглуулсан 18 төрлийн 69 ширхэг хувцас, тоглоом, цахилгаан хэрэгсэл, бичгийн хэрэгсэл гэх мэт эд зүйлсийг Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохжилтын хэлтсийн мэргэжилтэн н.Гантулгад 2019.06.08-ны өдөр хүлээлгэн өгсөн.

Тогтоол, захирамжийн төсөл боловсруулах, санал авах, шийдвэрлүүлэх ажлын хүрээнд

- СХД-ийн 12 дугаар хорооны Саппоро үйлчилгээний төвийн гадна талбайн нийтийн эзэмшлийн нийт 21,0 сая төгрөгийн хөрөнгийг акталж нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тогтоолын төсөл
- Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хавсралтад заасан нийт 441,3 сая төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 16 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасах тухай тогтоолын төсөл
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар БСШУЯамны “Тусгай сургуулийн сурагчдын автобус нийлүүлэх” БСШУЯ/201801073 дугаартай гэрээгээр Баянгол дүүргийн 70 дугаар тусгай сургуульд хуваарилагдсан 128,557,129.0 /нэг зуун хорин найман сая таван зуун тавин долоон мянга нэг зуун хорин есөн/ төгрөгийн үнэ бүхий “ММВ-800В” маркийн дунд оврын автобусыг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл
- Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй KIA OPTIMA маркийн 07-68УНҮ улсын дугаартай тээврийн хэрэгслийг Баянгол дүүргийн Гэр бүл, ёслолын ордон ОНӨТҮГ-ын балансад шилжүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл

НИЙСЛЭЛИЙН ӨМИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗАР

- Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны А/30 дугаар захирамжаар томилогдсон Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу худалдан авсан 19,900,000.0 /арван есөн сая есөн зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий PORTER-II маркийн хөргүүртэй ачааны автомашиныг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл
- Баянгол дүүргийн Засаг даргын 2019 оны А/227 дугаар захирамжийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд худалдан авсан 86,800,000.0 /наян зургаан сая найман зуун мянган/ төгрөгийн үнэ бүхий HUYNDAY STAREX H-I маркийн 14-98 УБУ улсын дугаартай микроавтобусыг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл
- Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Эд хөрөнгө актлах, худалдах, шилжүүлэх тухай” 61 дүгээр тогтоол, Хэнтий аймгийн Засаг даргын “Эд хөрөнгө актлах, худалдах, шилжүүлэх тухай” 2018 оны А/429 дүгээр захирамжийн дагуу Хүүхдийн төв сувилалд шилжүүлэхээр шийдвэрлэсэн 70,000,000.0 /далан сая/ төгрөгийн үнэ бүхий Nissan X-trial маркийн 48-80 ХЭҮ улсын дугаартай автомашиныг нийслэлийн өмчид бүртгэн авах тухай Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулан санал авч байна.

Цаашид авах арга хэмжээ:

1. Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэгтгэл, дүнг НИТХ-д өргөн барих
2. Дахин үнэлгээний явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах
3. Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/262 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулах
4. “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ыг шинэчлэн батлуулах
5. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээний захиалагчаар ажиллаж буй нийслэлийн төр захиргааны байгууллагуудаас холбогдох техникийн баримт бичгийг түргэн шуурхай авах, цаг алдалгүй бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулах
6. Өмчийн харилцаатай холбоотой дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчлэн боловсруулж НИТХ-д өргөн барьж хэлэлцүүлэх
7. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай, дүрэм, журам, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх
8. Албан хэрэг хөтлөлт, хариутай бичгийн шийдвэрлэлтийг сайжруулах дээд газрын цохолттой албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэх, эргэж танилцуулах асуудалд онцгой анхаарч ажиллах

Тайлантай танилцсан:

Ш.Үнэнбат /НӨАУГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч/

Тайлан нэгтгэсэн:

Ц.Цолмон /ЗСХ-ийн мэргэжилтэн/

Хяналт, шинжилгээ,

үнэлгээ хийсэн:

Ж.Сувданзаяа /ӨМХАХ-ийн мэргэжилтэн/